



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/19

Мөрөн


Зөвлөгөөн зохион байгуулах зардал  
гаргах тухай

Монгол улсын Засгийн газрын Төрийн албаны сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай 2018 оны 258 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2019 оныг "Иргэн төвтэй, үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх жил болгож" зарласантай холбогдуулан тус газрын нийт ажилтан албан хаагчид болон орон нутгийн сумдын орон тооны бус улсын байцаагч нарыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад зарцуулах төсөв, хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад зарцуулагдах 545 000 (таван зуун дөчин таван мянга) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага зардлаас гаргахыг нягтлан бодогч (М.Пагмажав)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга (Б.Сарантуяа)-д үүрэг болгосугай.



ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

14810114